



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 он нь Өмнөговь аймгийн хувьд “МОНГОЛ ТЭМЭЭ-999” арга хэмжээг амжилттай зохион байгуулан дэлхийн дээд амжилтыг шинэчлэн тогтоосон онцлог, түүхэн жил байлаа.



Нэг. Зохион байгуулсан ажил, үйл ажиллагааны үр дүн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2016 оныг “Хэрэглэгч баялаг бүтээгчдийг дэмжих жил” болгон зарлаж, Тэргүүлэгчдийн ажлын албанаас 67 заалт бүхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, төлөвлөсөн ажлынхаа 91%-ийг биелүүлэн, Төлөөлөгчдийн хуралдааныг 3 удаа, Тэргүүлэгчдийн хурлыг 18 удаа хуралдаж орон нутгийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлууд болон бодлогын чанартай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.



Төлөөлөгчдийн хуралдаан



Тэргүүлэгчдийн хурал

Дэлхийд тоогоороо тэргүүлдэг 2 бөхт тэмээн сүргийн үүлдэр шиг шимт чанарыг дээшлүүлэх, тоо толгойг өсгөх зорилгоор Ханын хэцийн Хүрэн, Галбын говийн улаан тэмээний үүлдрийг баталгаажуулж, тэмээн сүргийн амьдын үнэлэмжийг дээшлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх “МОНГОЛ ТЭМЭЭ-999” арга



хэмжээг амжилттай зохион байгуулан, 1000 тэмээ уралдуулж Геннисийн амжилтыг шинэчлэн тогтоолоо.



“Монгол тэмээ-999” дэлхийн дээд амжилтад бүртгүүлэх арга хэмжээ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, орон нутгийн удирдлагууд иргэдийн санаачлагаар говь нутагтаа буга нутагшуулах боломжийг олон жилийн өмнөөс судлан шинжилсний үр дүнд “Эрдэнэт үйлдвэр”-ийн удирдлага, Өмнөговь аймгийн Нутгийн зөвлөлтэй хамтран 2016 онд Орхон аймгаас 4 буга, 6 согоог “Говь гурван сайхан” ууландаа авчран нутагшуулах ажлыг зохион байгууллаа.



Буга нутагшуулах арга хэмжээ

Мөн нутгийн иргэдэд тулгуурласан говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, сарлаг сүргийн амьдын үнэлэмжийг нэмэгдүүлэх, уламжлалт нүүдэлчин малчин соёл, зан заншлыг сэргээх, сарлаг өсгөн үржүүлэгч малчдаа дэмжих, урамшуулах, идэвх санаачлагыг нь өрнүүлэх зорилгоор “Сайханы сарлаг” сарлагийн баярын арга хэмжээг жил бүрийн 5 дугаар сарын 4 дэх долоо хоногийн “бямба” гарагт говь гурван сайхан уулын Ёлын аманд зохион байгуулж байхаар шийдвэрлэлээ.



“Сайханы сарлаг” сарлагийн баярын арга хэмжээ



Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт метал хайгч ашиглахыг хориглосон аймгийн ИТХ-ын 2015 оны 136 дугаар тогтоолыг хүчингүй болгож, гар аргаар алт олборлож байгаа иргэдийн нөхцөл байдлыг судлаж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах ажлын хэсгийн тайланг хэлэлцэн Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолын дагуу аймгийн нутаг дэвсгэрт бичил уурхай ашиглах боломжтой ашигт малтмал бүхий газар нутгийн судалгаа хийж, журам боловсруулан ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

2016 он гарсаар ашигт малтмалын хайгуулын 25 хүсэлт ирснээс 15-ыг нь татгалзаж, 10-ыг нь дэмжсэн шийдвэр гаргасан бөгөөд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын хүсэлт 27 ирснээс 6-г татгалзаж, 21-ийг нь дэмжсэн байна. Дээрх хүсэлтүүдээс үзэхэд ихэвчлэн Ханбогд, Цогт-Овоо сумдад ашигт малтмалын хайгуул хийх хүсэлт ирсэн байна.

Ашигт малтмалын хайгуулын хүсэлт /тоогоор/

№	Нийт ирсэн хүсэлт	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	25	15	10

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хүсэлт /тоогоор/

№	Нийт ирсэн хүсэлт	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	27	21	6

Орон нутгийн бүтээн байгуулалтын ажлыг дэмжин Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл 25 км хатуу хучилттай авто зам, 170 км сайжруулсан шороон замын ажлыг эрчимжүүлэх зорилгоор элс, хайрга ашигласны төлбөрийг зам барих зориулалтаар 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд 80%-аар бууруулах шийдвэр гаргалаа.



Хатуу хучилттай болон сайжруулсан зам



Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн үндсэн болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллах нийт ажилчдын 50 хувиас доошгүй хувийг орон нутагт 3-аас дээш жил амьдарч байгаа нутгийн иргэдийг ажиллуулахыг уул уурхайн компаниудтай хамтран ажиллах гэрээнд тусгаж ажиллахыг аймгийн Засаг даргад үүрэг болголоо.

Орон нутгийн удирдлагын шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах зорилготой аймгийн Иргэний танхим 2016 онд 33 заалт бүхий төлөвлөгөө батлан хэрэгжүүлж “Боловсролын салбарын шинэчлэл, манай сургууль, цэцэрлэгүүд”, “18-35 насны залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх арга зам”, “Телекамерын ашиглалт, үр дүн, цаг үеийн нөхцөл байдал”, “Гэмт хэргийг бууруулахад иргэдийн оролцоо”, “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ” сэдэвт хэлэлцүүлэг, “Нийтийн эргүүлийн ажлын явц, үр дүн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмжийн хэрэглээ, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт зөвлөгөөнүүд болон 10 сургалтууд зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, иргэд, хэвлэл мэдээллийн 400 гаруй иргэд оролцож, хэлэлцүүлгээс гарсан 540 саналыг нэгтгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад чиглэл өгч ажиллалаа.



Иргэний танхимын хэлэлцүүлэг

Засгийн газрын 2016 оны 141 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтын дагуу аймгийн Засаг даргын дэргэд ажиллах Төрийн үйлчилгээний албыг байгуулж үйл ажиллагааг нь 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлээд байна.



Төрийн үйлчилгээний алба байгуулав



Аймгийн ИТХ-ын даргын санаачлагаар байгуулагдсан “МИНИ ПАРЛАМЕНТ” Даланзадгад сумын Ерөнхий боловсролын сургууль болон Политехникийн коллежийн сурагчдыг төлөөлсөн 33-41 сурагчийн бүрэлдэхүүнтэйгээр 3 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус Мини парламентаас нийтийн хог цэвэрлэгээ, илтгэл, мэтгэлцээний тэмцээн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн сурагчидтай хамтарсан спортын арга хэмжээг тус тус зохион байгуулаад байна.



ИТХ-ын дэргэдэх “Мини парламент”



ИТХ-ын дэргэдэх “Мини парламент”-ын хуралдаан

Монгол Улсад Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 24 жилийн ойд зориулж Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нэрэмжит шилжин явах цомын төлөөх уламжлалт Үндэсний бөхийн барилдаан, аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд илтгэл, эссэ бичлэгийн уралдааныг уламжлалын дагуу амжилттай зохион байгуулж, Шинэ үндсэн хуулийг батлахад аймаг орон нутгаа төлөөлөн оролцсон ахмад депутатуудад хүндэтгэл үзүүлээ.



Үндэсний бөхийн барилдаан



Аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн



ЕБС-ийн сурагчдын илтгэл, эссэ бичлэгийн уралдаан

2015 оны сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлыг дүгнэж нэгдүгээр байранд Сэврэй, хоёр, гуравдугаар байранд Гурвантэс, Баян-Овоо, тусгай байранд Даланзадгад, Манлай сумын ИТХ тус тус шалгарлаа.

Төрийн дээд шагналд 312 хүний материалыг бүрдүүлэн Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлснээс Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 3, Алтан гадас одонгоор 41, Цэргийн гавъяаны одонгоор 1, Хөдөлмөрийн хүндэт медалиар 30, Цэргийн хүндэт медалиар 5, нийт 80 иргэн, “Эхийн алдар-1, 2” дугаар одонгоор 138 эх шагнагдлаа.




Аймаг орон нутгийн хөгжил цэцэглэлт, ард иргэдийн сайн сайхан амьдрал, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын тогтолцоог төлөвшүүлэх, төр, засгийн тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвх зүтгэл гарган, үр дүнтэй ажилласан зарим хүмүүсийг аймгийн дээд шагнал болон ИТХ-ын шагналаар шагнаж урамшуулсан. Үүнд: аймгийн ИТХ-ын “Хүндэт тэмдэг”-ээр 5 хүн, “Хүндэт жуух” бичгээр 50 хүн, “Хүндэт өргөмжлөл”-өөр 35 хүн шагнагдсан байна.



Аймгийн ИТХ-ын 2016 оны нийт төсөв 377,7 сая төгрөг батлагдсан ба үүнээс ИТХ-д суудалтай намд олгох дэмжлэгт 41,2 сая, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн зардалд 17,8 сая, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөлийн зардалд 3,8 сая, Иргэний зөвлөлийн зардалд 11,8 сая, Хурлын даргын нөөц хөрөнгөд 71,5 сая, урсгал зардалд 231,5 сая төгрөг зарцуулсан



болно.



Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан.

2016 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан дунджаар 69 хувийн ирцтэй 3 удаа хуралдаж нийт 19 асуудал хэлэлцэж, 57 заалт бүхий 20 тогтоол баталлаа. Үүнд:

Орон нутгийн төсвийн тодотголоор 2016 оны төсвийг 7,0 тэр бум төгрөгөөр нэмэгдүүлэн 110,6 тэр бум төгрөгөөр, төсвийн орлогыг 210,6 сая төгрөгөөр бууруулан 58,0 тэр бум төгрөгөөр, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлыг 4,0 тэр бум төгрөгөөр нэмэгдүүлэн 44,1 тэр бум төгрөгөөр баталсан.

Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бүлэг, 16 зорилт, 166 заалт, 17 дэд хөтөлбөрийн хамт батлан хэрэгжүүлж байна.

Мөн аймгийн ИТХ-аас 2017-2020 онд баримтлах үзэл баримтлал, хуралдааны дэг, хороодын ажиллах журам, бүрэлдэхүүнийг баталж, Тэргүүлэгчдийн 2016 оны тайланг хэлэлцэж дүгнэлээ.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт 85 хувьтай дүгнэгдэж, 2017 оны үндсэн чиглэлийг 3 бүлэг 185 заалттайгаар баталлаа.

2015 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн орлогын хэмжээг 70 134 468 900 төгрөгөөр, тусгай зориулалтын төсвийн гүйцэтгэлийн орлогын хэмжээг 24 935 947 800 төгрөгөөр, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын хэмжээг 66 871 217 200 төгрөгөөр, тусгай зориулалтын төсвийн гүйцэтгэлийн зарлагын хэмжээг 24 639 344 700 төгрөгөөр тус тус баталлаа.

Орон нутгийн 2017 оны төсвийн орлого, зарлагын хэмжээг 103,080,283.7 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлыг 28,255,314.7 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас сумдын орон нутгийн хөгжлийн





санд олгох орлогын хэмжээг 4402645,6 мянган төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 28,417,470.5 мянган төгрөгөөр баталлаа.

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгууль амжилттай явагдаж, шинэ эрхийн хугацаа эхэлсэнтэй холбогдуулан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд УИХ-ын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хамтран шинээр сонгогдсон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн суурь сургалтыг 2016 оны 11 дүгээр сарын 21-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж нийт 275 Төлөөлөгч хамрагдлаа.



Орон нутгийн ээлжит сонгуулийн бүрэн эрхийн хугацаа эхэлж байгаа энэ үед НӨУБ-ын эрх зүйн үндэс, Иргэдийн оролцоо, НӨУБ-ын зохион байгуулалт, Байгаль орчин, Төсөв санхүүгийн чиглэлээр аймаг, сумын Төлөөлөгчдөд сургалт зохион байгуулж байгаа нь Төлөөлөгчид орон нутагтаа Нутгийн Өөрөө Удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх, өмч, эдийн засаг, санхүү, байгаль орчин, хүний нөөцийн асуудлаа өөрсдөө мэддэг, асуудлыг бие даан шийдвэрлэдэг, гаргасан шийдвэр нь иргэдийн бодит амьдралд нөлөөлж чадахуйц чухал үр дүнтэй юм.

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төлөөлөгч тус бүрт жилд нэг сая төгрөгний дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Гурав. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны хүрээнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурал 18 удаа хуралдаж, аймаг орны нийгэм, эдийн засгийн 150 асуудал хэлэлцэн, 413 заалт бүхий 165 тогтоол батлан хэрэгжүүлж байна.

Дээрх хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрүүдийн 21 хувийг нийгмийн, 6 хувийг эдийн засгийн, 30 хувийг дэд бүтэц, хөдөө аж ахуй, байгаль орчин, 16 хувийг орон нутгийн өмч, 15 хувийг шагнал урамшуулал, 12 хувийг бусад асуудал эзэлж байна.



Тэргүүлэгчдийн хурал

**Хэлэлцсэн баталсан зарим шийдвэрүүдээс дурдвал:****- Нийгмийн бодлогын хүрээнд**

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Аюулгүй Өмнөговь”, “Орчны эрүүл мэнд”, “Эрүүл шүд”, “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх”, “Хүмүүнлэг”, “Элэг бүтэн Өмнөговьчууд”, “Эх хүүхдийн эрүүл мэнд”, “Хүүхэд – Хөгжлийн түлхүүр”, “Оюуны хурд”, “Багш-Хөгжил”, “Англи хэлтэй Өмнөговь”, “Говийн дэмжлэг”, “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх”, “Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх” зэрэг хөтөлбөрүүд,

“Хурдан морины бүсийн уралдаан зохион байгуулах”, “Хурдан тэмээний уралдаан зохион байгуулах”, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох”, “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгуулагдсан хөрөнгийг хаягжуулах”, Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “School police” эргүүл ажиллуулах зэрэг журмууд болон Тэргүүлэгчдийн хурлын дэг, ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам, Даланзадгад сумыг Улсын Тэргүүний суманд тодорхойлох, Сарлагийн баярын тов тогтоох, аймгийн Засаг даргын дэргэдэх “Төрийн үйлчилгээний алба” байгуулах, Бүсийн эмчилгээ оношилгооны төвийг МУ-ын гавъяат эмч Хоролын Шаравын нэрэмжит болгох, Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн хэмжээг бууруулах, олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц өндөр чадвартай, боловсролтой “Зөв монгол хүн”-ийг төлөвшүүлэх уриалга зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталлаа.

- Эдийн засаг, өмч санхүүгийн бодлогын хүрээнд

Орон нутгийн өмчит “Гүний-Ус” хязгаарлагдмал хариуцлагатай компани, “Таван Толгой” хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, “Таван Толгой” хувьцаат компанийн нүүрсийг 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд Өмнөговь аймгийн төв болон сумдын айл өрх, төсөвт байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад 1 тонныг 8000 төгрөгөөр худалдах чиглэлийг Төлөөлөн удирдах зөвлөлд өгсний дагуу нүүрсний үнийг уурхайн амнаас 8000 төгрөгөөр худалдан, иргэд, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагын өвөлжилтийн бэлтгэлийг хангалаа.

Мөн орон нутгийн өмчийн албыг татан буулгаж, аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн газрыг байгууллаа.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын 2015 оны санхүүгийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлээр эргэлтийн хөрөнгө 53,3 тэр бум, эргэлтийн бус хөрөнгө 300,8 тэр бум, нийт хөрөнгийн дүнг 354,1 тэр бум төгрөгөөр баталлаа.

Орон нутгийн өмчийн хөрөнгийг хаягжуулах, хөрөнгө актлах, шилжүүлэх, худалдах, хөрөнгийн дүн бүртгэх тухай асуудлуудыг хэлэлцэн нийт 28 тогтоолоор 39 байгууллагын 8,8 тэр бум төгрөгийн хөрөнгийн асуудал хэлэлцэж шийдвэрлэлээ. Үүнд:

4,5 тэр бум төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 573,2 сая төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хасч, 27 сая төгрөгний хөрөнгийг дуудлага



худалдаагаар, 890 мянган төгрөгний хөрөнгийг үнэ тогтоон худалдаж, 3,7 тэр бум төгрөгний хөрөнгө шинээр бүртгэсэн байна.

- Ажлын хэсэг байгуулан ажиллах хүрээнд

Говь гурван сайхан ууланд буга нутагшуулах, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, Төсвийн бүрдүүлэлт зарцуулалтад хяналт, дүгнэлт гаргах, Уул уурхайн салбарт ажиллаж байгаа орон нутгийн иргэдийн хүний нөөц, боловсон хүчний хангалтад хяналт хийж дүгнэлт гаргах, “Пибоди винсвей ресорсез” компаний нөхөн олговорын асуудлыг судлан, санал боловсруулах, Хууль бус аргаар алт олборлогчдын нөхцөл байдлыг судалж, санал боловсруулах, “Таван Толгой” ХК-ний санхүүг шалгах ажлын хэсгүүд болон иргэний танхимаас зохион байгуулж буй нээлттэй хэлэлцүүлэг тус бүрт ажлын хэсэг байгуулан ажиллуулж, үр дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцлээ.

- Аймгийн ИТХ-аас байгуулсан ажлын хэсэг болон зарим байгууллагын үйл ажиллагааны тайлан, мэдээллийг сонсч үүрэг чиглэл өгсөн талаар:

Аймгийн авто тээврийн төвийн үйл ажиллагааны тайлан, уул уурхайн нөлөөллийн сумдын усны нөөцийн өнөөгийн байдал, байгаль орчны талаар гарч байгаа зөрчлүүд, түүнийг арилгах арга замын тухай мэдээлэл, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн болон Тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилт, Иргэний танхимын хэлэлцүүлгүүд болон Тэргүүлэгчдийн хурлаас байгуулсан ажлын хэсгүүдийн тайланг хэлэлцэж, аймгийн Засаг дарга, ЗДТГ, хэлтэс, агентлагуудад үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

- Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд

2016 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас батлагдсан 52 орчим бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тооцон ажиллаж байгаа бөгөөд хяналтаас хасагдсан 70 тогтоолоос 100% хэрэгжсэн 56, 80-90% хэрэгжсэн 14 тогтоол байна. Үүнд: Хөдөө аж ахуй, байгаль орчин, дэд бүтцийн салбарын 8, эрүүл мэнд, нийгмийн салбарын 6 хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэн үүрэг чиглэл өглөө. Тухайлбал:

- Байгаль орчны мастер төлөвлөгөөний хэрэгжилт 84,4%
- Хүнс хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт 81%
- Газар тариалангийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт 84,4%
- Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт 81,5%
- Ой дэд хөтөлбөрийн хэрэгжилт 85,4%-тай
- “Ойн менежментийн төлөвлөгөө”-ний хэрэгжилт 86.9%
- “Даланзадгад сумын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-ний хэрэгжилт 80%
- “Байгалийн баялаг-сайн засаглал-хөгжсөн Өмнөговь” хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц 50,9 %-тай гэж дүгнэгдлээ.

Мөн “Сүү, тараг”, “Эрүүл мэндийн шинэчлэл”, “Эрүүл хот”, “Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг хөгжүүлэх”, Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээлт”, “Өрх гэр бүлийг дэмжих”, “40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр




эрхлэлтийг дэмжих, ажил орлоготой эмэгтэйчүүд”, “Архигүй Өмнөговь” зэрэг хөтөлбөрийн явцын хэрэгжилтийг хэлэлцэж дүгнэлээ.

Тэргүүлэгчдийн ажлын төлөвшилт:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хүний эрхийн Үндэсний комисстой 2015 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулсаны хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссоос Даланзадгад сумын иргэдэд хүний эрхийн талаар сургалт сурталчилгаа зохион байгууллаа.


Аймгийн ИТХ-ын байнгын тасралтгүй үйл ажиллагааг хангах үүрэг бүхий Тэргүүлэгчид өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлуудаар улирал бүр тогтоолын эмхтгэл гарган Төлөөлөгчдөд хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд шийдвэрийг тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийн цахим хуудсаар дамжуулан сурталчилж байна.



ИТХ-ын Тэргүүлэгчдийг дэмжих зорилгоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний урамшууллыг улирал бүр олгож байна.

Дөрөв. Хяналт шалгалтын ажил.

Тэргүүлэгчдийн шийдвэрээр байгуулагдсан Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг аймгийн хэмжээний 214 байгууллагад хяналт хийхэд хуулийн хэрэгжилт 97,2 хувьтай байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд оруулвал зохих 9333 мэдээнээс 6361 буюу 68.2% нь мэдээлэгдэж баталгаажсан байна. Хэдийгээр хуулийн хэрэгжилт сайн байгаа ч хуулийн хугацаа хоцрох, ямар мэдээ оруулахаа мэдэхгүй байх алдаа дутагдал байлаа.



Шилэн дансны хуулийн хэрэгжилт шалгах ажлын хэсэг

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр төсвийн бүрдүүлэлт зарцуулалтад хяналт хийж, санал боловсруулах ажлын хэсгийг



байгуулан ажиллаж, ажлын хэсгийн тайланг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн аймгийн Засаг даргад “Төсвийн орлогыг төлөвлөх, бүрдүүлэх, хяналтыг сайжруулах, Татвар, Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч үр дүнг тооцох, өнгөрсөн хугацаанд санхүүгийн тооцоо, хяналтыг сулруулсан ажилтнуудад хариуцлага тооцох. орон сууцны барилгын эргэн төлөгдөх санхүүжилтын хугацаандаа төлөгдөөгүй байгаа хөрөнгийн ногдол алданги, торгуулийн гаргуулан авах, шалгалтаар илэрсэн төсвийн зарцуулалтын зөрчлүүдийг хууль, хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх, “Хөгжил хөрөнгө оруулалтын сан” ХХК, “Даланзадгад дулаан хангамжийн газар” ОНӨААТҮГазар, “Даланзадгад” ДЦС-ын асуудлыг судлан цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулах, Төсвийн тухай хуулийн дагуу төрийн сангууд түүний дансыг нэгтгэх, сангуудын журмыг шинэчлэн боловсруулж батлуулах, “Зам засвар арчлалтын анги” байгуулах асуудлыг судлан боловсруулах, төрийн албан хаагчийн хүнд суртал, ажил үүргийн давхацлыг арилгах, хариуцлагыг сайжруулах, мэргэжлийн чиг баримжаа бүхий хэлтэс албад ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажил дүгнэх журмыг шинэчлэн боловсруулж мөрдөх” зэрэг үүрэг даалгаварыг өгч ажиллалаа.

Тав. Бусад ажил.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн анхааралд байдаг гол асуудлын нэг нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил мөн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2016 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “School police” эргүүлийн ажиллах журмыг батлан хэрэгжүүлж, “Хууль сурталчлах”, “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг тэг болгоё” аян, “Ногоон гэрэл-Цагаан шугам”, “Автомашингүй өдөр” арга хэмжээ, “Нийтийн эргүүлийн ажлын явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ”, “Бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмжийн хэрэглээ, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт зөвлөгөөн, “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, “Өсвөрийн цагдаа бүлгэмийн уулзалт” зэрэг томоохон ажлуудыг зохион байгууллаа.



“Автомашингүй өдөр” арга хэмжээ



“Ногоон гэрэл-Цагаан шугам” арга хэмжээ



Мөн олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд “Хот амгалан уу” сэдэвт цаг үеийн нөхцөл байдлыг харуулсан цуврал нэвтрүүлэг, “Халуун цэг”, “Сумын цагдаагийн нэг өдөр” зэрэг телевизийн нэвтрүүлэг бэлтгэн иргэдэд хүргэлээ.



“Автомашингүй өдөр” арга хэмжээ

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын ажлын хүрээнд:

Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаатай салшгүй холбоотой нэг ажил бол Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар зөвлөлийн ажил билээ.

2016 онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн ар гэр, үр хүүхдүүдэд нөхөн оловдор хөөцөлдөж байгаа болон цагаатгалтай холбоотой асуудлаар өргөдөл 10, санал 33, хүсэлт 14 хүлээн авч 54 иргэнтэй уулзаж зөвлөгөө өглөө.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг угтаж “Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршиг” лекцийг сумдын ИТХ-д албан тоотоор хүргүүлэн, “Улс төрийн хэлэмэгдүүлэлт ба цагаатгал 1, 2” баримтат киног орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлж, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн нөхөн олговор 2 хүнд 2 сая төгрөг олголоо.



Сумдад ажилласан ажлын хүрээнд:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Цогтцэций, Ханбогд, Ноён, Сэврэй, Гурвантэс зэрэг 10 гаруй сумдад ажиллаж аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгах иргэдийн саналыг нь авч, иргэд, аж





ахуй нэгжийн өвөлжилтийн бэлтгэл ажил, “Эрдэнэс таван толгой”, “Таван толгой”, “Энержи ресурс”, “Оюу толгой”, “Хүннү ресурс” зэрэг компаниудын үйл ажиллагаатай танилцлаа.

Мөн аймгийн удирдлагуудын хамт аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, захирал нартай нэгдсэн уулзалт хийж санал бодлыг нь сонсон, Даланзадгад сумын сургуулиудын засвар, барилгын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан зарим сургуулиудад тодорхой үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс цаашид дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Төлөөлөгчдийн суурь сургалтанд хамрагдаагүй шинээр сонгогдсон аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, багийн Иргэдийн Нийтийн хурлын даргыг чадавхжуулах сургалт зохион байгуулах

- Төлөөлөгчид хуралдаанд асуудал санаачлан хэлэлцүүлэх, орон нутгийн тулгамдсан асуудлаар холбогдох албан тушаалтанд асуулга тавьж, хариу авах зэрэг Төлөөлөгчдийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах

- Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдээс батлан хэрэгжүүлж буй шийдвэрийн хэрэгжилтийг тооцож, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй байгаа тогтоолын хяналтыг сайжруулах

- Байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа, гэмт хэргийг хянан шалгах, таслан зогсоох талаар бүх талын арга хэмжээ авах

- Иргэдийн дуу хоолой, санал бодлыг шийдвэр гаргах түвшинд хүргэх, иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулах, сургалт сурталчилгаа явуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх болно.

Тайлан хянасан:

Аймгийн ИТХТ-ийн
ажлын албаны дарга

Б.Галхүү

Тайлан бичсэн:

Аймгийн ИТХТ-ийн
ажлын албаны ажилтан

О.Батчимэг

2017.01.17